



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/86

Мандалговь

“Гамшгийн эрсдэлийг бууруулах нөөц” ажлын<sup>т</sup>  
батлагдсан зардлаас Короновирусын цар тахлаас  
урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор хамгаалах хувцас  
хэрэгсэл хүлээн авах комисс ажиллуулах тухай

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.1, 4.13 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Короновирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор хамгаалах хувцас хэрэгсэл хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Нарийн бичиг: Ж.Цэцэгдэлгэр (Онцгой байдлын газрын 124-р салбарын дарга)

Гишүүд:  
Б.Ширчмаа (Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн )  
О.Элбэгзаяа (Онцгой байдлын газрын нярав)  
Н.Батжаргал (“Жирмийн булаг” ХХК-ны захирал)

2. Батлагдсан гэрээний дагуу хамгаалах хувцас хэрэгслийг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бурдүүлэн ажиллахыг комиссын дарга (А.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Дорж* Л.ДОРЖБАТ

486210373